

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүмбэр сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГСА-2024/32/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Говьсүмбэр аймаг 2024 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас: 70543179 Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn Аудитын менежер: Г.Наранбаяр Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Анхтуяа Цахим хаяг: ankhtuyab@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	17
4.1 Ерөнхий зүйл .....	17
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
4.5.1 Завсрын аудитын талаар.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	19
5.1Төлбөрийн акт .....	19
5.2 Албан шаардлага .....	20
5.3 Зөвлөмж .....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	21

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БХНСАХЗ	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг

Утас/Факс:976-7054 3179

И-мэйл: goviumber@audit.gov.mn

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН СҮМБЭР  
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ  
П.НАРАНМАНДАХ ТАНАА

2024.02.26 № 24  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

008020064



## **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 19 зорилтын хүрээнд 144 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 91.3 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА





## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,055,147,185.00</b>	<b>1,152,673,066.05</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>11,941,929.00</b>	<b>20,440,688.00</b>
<b>31100</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	<b>0.00</b>	<b>200,000.00</b>
31110	Төгрөг	0.00	200,000.00
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>11,941,929.00</b>	<b>20,240,688.00</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>11,941,929.00</b>	<b>20,240,688.00</b>
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	11,941,929.00	20,240,688.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>265,000.00</b>	<b>531,206.05</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	531,206.05
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>265,000.00</b>	<b>0.00</b>
33510	Байгууллагаас авах авлага	265,000.00	0.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>1,007,809,256.00</b>	<b>1,084,386,256.00</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>949,599,256.00</b>	<b>1,026,176,256.00</b>
35410	Бичиг хэргийн материал	306,200.00	765,000.00
35420	Аж ахуйн материал	49,852,203.00	65,361,903.00
35430	Сэлбэг хэрэгсэл	0	567,500.00
35450	Барилгын засварын материал	2,694,000.00	9,655,500.00
35470	Бусад хангамжийн материал	896,746,853.00	949,826,353.00
35600	Мал амьтад	58,210,000.00	58,210,000.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	<b>35,131,000.00</b>	<b>47,314,916.00</b>
36300	Тэжээлийн нөөц	35,131,000.00	47,314,916.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>911,793,344.82</b>	<b>676,723,909.07</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>911,793,344.82</b>	<b>676,723,909.07</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>862,237,511.68</b>	<b>627,426,409.07</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	661,599,166.24	348,225,098.06
39202	Хуримтлагдсан элэгдэл	-177,466,852.21	-152,123,198.53
39203	Авто-тээврийн хэрэгсэл	39,420,000.00	52,270,650.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-8,484,000.00	-18,138,995.83
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	75,553,100.00	102,167,610.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-48,678,427.79	-67,664,328.05
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	74,199,460.00	73,559,480.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-42,541,215.25	-48,983,665.40
39214	Бусад үндсэн хөрөнгө	639,606,964.00	736,411,955.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-350,970,683.31	-398,298,196.18
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>49,555,833.14</b>	<b>49,297,500.00</b>
39301	Програм хангамж	1,750,000.00	1,750,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,334,166.86	-1,592,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	49,140,000.00	49,140,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,966,940,529.82</b>	<b>1,829,396,975.12</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>9,142,997.93</b>	<b>0.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>9,142,997.93</b>	<b>0.00</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>9,142,997.93</b>	<b>0.00</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,434,559.93	0.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	3,254,272.00	0.00
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>3,454,166.00</b>	<b>0.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	3,189,166.00	0.00



41362	Хувь хүмүүст төлөх өглөг	265,000.00	0.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,957,797,531.89</b>	<b>1,829,396,975.12</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,957,797,531.89</b>	<b>1,829,396,975.12</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	786,753,176.71	786,753,176.71
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	786,753,176.71	786,753,176.71
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>696,222,453.50</b>	<b>891,675,781.33</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	727,082,339.65	1,030,291,610.10
51220	Тайлант үеийн үр дүн	-30,859,886.15	-138,615,828.77
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	474,821,901.68	150,968,017.08
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,966,940,529.82</b>	<b>1,829,396,975.12</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,249,215,111.00</b>	<b>1,991,886,010.38</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>105,940,411.00</b>	<b>210,456,910.38</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>105,940,411.00</b>	<b>210,456,910.38</b>
120003	Торгуулийн орлого	137,336.00	0.00
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>0.00</b>	<b>200,000.00</b>
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	0.00	200,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	72,736,275.00	135,277,074.38
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	33,066,800.00	74,979,836.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,143,274,700.00</b>	<b>1,781,429,100.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>1,315,000.00</b>	<b>31,340,000.00</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,315,000.00	31,340,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>1,141,959,700.00</b>	<b>1,750,089,100.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,141,959,700.00	1,750,089,100.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,271,021,190.34</b>	<b>1,882,799,529.41</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,271,021,190.34</b>	<b>1,882,799,529.41</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,174,777,976.40</b>	<b>1,792,161,502.15</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>350,749,983.20</b>	<b>634,036,113.13</b>
210101	Үндсэн цалин	244,009,310.20	343,401,968.04
210102	Нэмэгдэл	56,022,809.00	214,142,420.79
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,818,060.00	38,826,925.14
210104	Урамшуулал	20,693,035.00	37,664,799.16
210105	Гэрээт ажлын хөлс	9,206,769.00	0.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>42,539,300.00</b>	<b>77,732,245.72</b>
210201	Тэтгэврийн даатгал	30,970,468.84	56,949,858.63



210202	Тэтгэмжийн даатгал	2,898,500.00	5,504,337.82
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,318,800.00	4,212,111.09
210204	Ажилгүйдлийн даатгал	554,431.16	1,558,502.08
210205	Эрүүл мэндийн даатгал	5,797,100.00	9,507,436.10
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>48,103,592.09</b>	<b>92,903,480.49</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,654,054.09	8,095,656.49
210302	Түлш, халаалт	35,888,266.00	81,154,273.00
210303	Цэвэр, бохир ус	8,561,272.00	3,653,551.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>26,498,062.50</b>	<b>40,334,014.42</b>
210401	Бичиг хэрэг	6,847,760.00	7,500,400.00
210402	Тээвэр, шатахуун	9,235,300.00	12,624,138.32
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,603,831.00	3,249,058.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	192,000.00	261,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,796,271.50	2,373,718.10
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,822,900.00	12,059,700.00
210408	Бараа материал акалсны зардал	0.00	2,266,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,816,740.00</b>	<b>9,383,500.00</b>
210604	Урсгал засвар	3,816,740.00	9,383,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>8,702,000.00</b>	<b>12,348,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	8,702,000.00	12,348,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>534,889,540.00</b>	<b>717,140,418.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	532,653,672.00	715,242,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,502,600.00	1,167,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	185,268.00	67,768.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	460,000.00	575,100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>159,478,758.61</b>	<b>208,283,730.39</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	51,213,670.20	68,906,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	478,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	108,265,088.41	138,899,130.39
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>96,243,213.94</b>	<b>90,638,027.26</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>39,560,536.00</b>	<b>6,795,000.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,161,400.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	28,399,136.00	6,795,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>56,682,677.94</b>	<b>83,843,027.26</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	56,682,677.94	83,843,027.26
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>-21,806,079.34</b>	<b>109,086,480.97</b>



V	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>9,053,806.81</b>	<b>247,702,309.74</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	9,053,806.81	247,702,309.74
VI	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-30,859,886.15</b>	<b>-138,615,828.77</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

		/ төгрөгөөр /	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,154,205,092.00</b>	<b>1,801,601,859.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>10,930,392.00</b>	<b>19,907,759.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>10,930,392.00</b>	<b>19,907,759.00</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>10,930,392.00</b>	<b>19,707,759.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,930,392.00	19,707,759.00
120009	Бусад орлого	0.00	200,000.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,143,274,700.00</b>	<b>1,781,694,100.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>1,315,000.00</b>	<b>31,605,000.00</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,315,000.00	31,605,000.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>1,141,959,700.00</b>	<b>1,750,089,100.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,141,959,700.00	1,750,089,100.00
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,139,595,700.00</b>	<b>1,783,809,170.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,139,595,700.00</b>	<b>1,783,809,170.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,043,352,486.06</b>	<b>1,693,171,142.74</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>359,068,579.27</b>	<b>656,770,615.99</b>
210101	Үндсэн цалин	251,236,342.27	346,428,711.90
210102	Нэмэгдэл	58,803,543.00	233,850,179.79
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,238,197.00	38,826,925.14
210104	Урамшуулал	20,693,035.00	37,664,799.16
210105	Гэрээт ажлын хөлс	7,097,462.00	0.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>42,579,200.00</b>	<b>77,671,267.84</b>
210201	Тэтгэврийн даатгал	30,985,100.00	62,946,667.84
210202	Тэтгэмжийн даатгал	2,898,500.00	3,681,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,318,800.00	2,033,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	579,700.00	1,647,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,797,100.00	7,362,600.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>41,660,154.09</b>	<b>96,092,646.49</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,654,054.09	8,095,656.49
210302	Түлш, халаалт	32,699,100.00	84,339,539.00
210303	Цэвэр, бохир ус	5,307,000.00	3,657,451.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>19,299,730.50</b>	<b>24,220,966.10</b>



210401	Бичиг хэрэг	5,566,800.00	7,114,200.00
210402	Тээвэр, шатахуун	9,135,300.00	11,192,940.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,603,831.00	3,169,058.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	433,300.00	261,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	560,499.50	2,483,768.10
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>584,651.00</b>	<b>0.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	584,651.00	0.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,956,640.00</b>	<b>29,448,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	137,000.00	1,813,500.00
210604	Урсгал засвар	5,819,640.00	27,634,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>8,702,000.00</b>	<b>12,348,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	8,702,000.00	12,348,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>536,079,540.00</b>	<b>717,140,418.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	533,843,672.00	715,242,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,502,600.00	1,167,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	185,268.00	67,768.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	460,000.00	575,100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>29,421,991.20</b>	<b>79,479,228.32</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,421,991.20	79,000,728.32
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	478,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>96,243,213.94</b>	<b>90,638,027.26</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>39,560,536.00</b>	<b>6,795,000.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,161,400.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	28,399,136.00	6,795,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>56,682,677.94</b>	<b>83,843,027.26</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	56,682,677.94	83,843,027.26
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>14,609,392.00</b>	<b>17,792,689.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>8,779,000.00</b>	<b>9,293,930.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>8,779,000.00</b>	<b>9,293,930.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>8,779,000.00</b>	<b>9,293,930.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,779,000.00	9,293,930.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-8,779,000.00</b>	<b>-9,293,930.00</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>5,830,392.00</b>	<b>8,498,759.00</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,111,537.00	11,941,929.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	11,941,929.00	20,440,688.00



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /
					Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	786,753,176.71	473,051,901.68	727,082,339.65	1,986,887,418.04
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	786,753,176.71	473,051,901.68	727,082,339.65	1,986,887,418.04
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	1,770,000.00	0.00	1,770,000.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-30,859,886.15	-30,859,886.15
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	786,753,176.71	474,821,901.68	696,222,453.50	1,957,797,531.89
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	786,753,176.71	474,821,901.68	696,222,453.50	1,957,797,531.89
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	334,069,156.60	334,069,156.60
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	786,753,176.71	474,821,901.68	1,030,291,610.10	2,291,866,688.49
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-323,853,884.60	0.00	-323,853,884.60
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-138,615,828.77	-138,615,828.77
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	786,753,176.71	150,968,017.08	891,675,781.33	1,829,396,975.12



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,750,089,100.00</b>	<b>1,666,246,072.74</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,750,089,100.00</b>	<b>1,666,246,072.74</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,742,589,100.00</b>	<b>1,659,496,072.74</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>656,925,300.00</b>	<b>656,770,615.99</b>
210101	Үндсэн цалин	358,035,200.00	346,428,711.90
210102	Нэмэгдэл	267,678,000.00	233,850,179.79
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,616,500.00	38,826,925.14
210104	Урамшуулал	24,595,600.00	37,664,799.16
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>84,401,000.00</b>	<b>77,671,267.84</b>
210201	Тэтгэврийн даатгал	69,676,400.00	62,946,667.84
210202	Тэтгэмжийн даатгал	3,681,000.00	3,681,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,033,100.00	2,033,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,647,900.00	1,647,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,362,600.00	7,362,600.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>98,175,000.00</b>	<b>96,092,646.49</b>
210301	Гэрэл, цахилгаан	9,440,000.00	8,095,656.49
210302	Түлш, халаалт	82,035,000.00	84,339,539.00
210303	Цэвэр, бохир ус	6,700,000.00	3,657,451.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>25,519,000.00</b>	<b>23,739,466.10</b>
210401	Бичиг хэрэг	6,634,000.00	6,632,700.00
210402	Тээвэр, шатахуун	12,000,000.00	11,192,940.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,961,000.00	3,169,058.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	440,000.00	261,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,484,000.00	2,483,768.10
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>40,413,000.00</b>	<b>37,091,910.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,650,000.00	6,577,410.00
210602	Тавилга	4,500,000.00	2,880,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	300,000.00	0.00
210604	Урсгал засвар	28,963,000.00	27,634,500.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>16,178,300.00</b>	<b>12,348,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	16,178,300.00	12,348,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>721,413,800.00</b>	<b>717,140,418.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	717,809,800.00	715,242,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	850,000.00	0.00



210803	Даатгалын үйлчилгээ	1,500,000.00	1,167,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	234,000.00	67,768.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	200,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	720,000.00	575,100.00
210807	Газрын төлбөр	100,000.00	0.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>99,563,700.00</b>	<b>38,641,748.32</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	98,113,700.00	38,163,248.32
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,450,000.00	478,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>7,500,000.00</b>	<b>6,750,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>7,500,000.00</b>	<b>6,750,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,500,000.00	6,750,000.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,750,089,100.00</b>	<b>1,666,246,072.74</b>
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,750,089,100.00</b>	<b>1,666,246,072.74</b>
320001	Орон нутгийн төсвөөс	1,750,089,100.00	1,666,246,072.74
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>34.00</b>	<b>34.00</b>
620001	Удирдах ажилтан	9.00	9.00
620002	Гүйцэтгэх ажилтан	18.00	18.00
620003	Үйлчлэх ажилтан	3.00	3.00
620004	Гэрээт ажилтан	4.00	4.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

		/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>31,605,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>29,954,980.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>29,909,980.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>481,500.00</b>
210401	Бичиг хэрэг	481,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>29,428,480.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,428,480.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>45,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>45,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	45,000.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,650,020.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>1,650,020.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,650,020.00
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>31,605,000.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>31,605,000.00</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	31,605,000.00



### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Сүмбэр сумын Засаг даргын тамгын газрын чиг үүрэг нь "Төр, эдийн засаг, нийгмийн бодлогын удирдлагын үйл ажиллагаа" юм. Эрхэм зорилго нь

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

- Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт
- Засгийн газрын 2023 оны 240 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай"
- Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай"

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүмбэр сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сүмбэр сумын Засаг даргын тамгын газар нь Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2018 оны А/167 дугаар тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөж байгаа ба зарим нэг хууль тогтоомжийн өөрчлөлтийг эс тооцвол нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

#### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Сүмбэр сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 137,543.5 мянган төгрөгөөр буюу 7.0 хувиар буурсан байна.



## Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	11,941.9	20,440.7	8,498.8
Авлага	265.0	531.2	266.2
Урьдчилгаа	0.0	00	0.0
Бараа материал	1,042,940.3	1,131,701.2	88,760.9
Үндсэн хөрөнгө	911,793.3	676,723.9	-235,069.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,966,940.5</b>	<b>1,829,397.0</b>	<b>-137,543.5</b>
Өр төлбөр	9,143.0	0.0	-9,143.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,957,797.5	1,829,397.0	-128,400.5
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,966,940.5</b>	<b>1,829,397.0</b>	<b>-137,543.5</b>

Дээрх хүснэгтээс харахад дараах нөлөө бүхий дансанд материаллаг хэмжээний өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 8,498.8 мянган төгрөгөөр өссөн нь ахмадын санг нэмэгдүүлснээс шалтгаалжээ.
- Авлага данс 266.2 мянган төгрөгөөр нэмэгдэж, 531.2 мянган төгрөгийн ХХОАТ-ын авлага үүссэн байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 1,131,701.2 мянган төгрөг болж 88,760.9 мянган төгрөгөөр өссөн нь УТХО-аас шалтгаалсан байна. УТХО-аар хүлэмж 53,530.0 мянга, сумын ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар 18,649.9 мянга, өвөлжилт хүндэрсэн малчдад туслах хандив тусламж 2,612.7 мянга, бусад 187.2 мянга, нийт 74,979.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, даргын 2023 оны А/12 дугаар тушаалаар бараа материал акталсан байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 676,723.9 мянган төгрөг болж 235,069.4 мянган төгрөгөөр буурсан нь хуучин конторын барилгыг шилжүүлснээс шалтгаалжээ. Тухайлбал, үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалт 9,293.9 мянга, аймгийн ОНХО-аар 89,655.6 мянга, УТХО-аар 12,128.6 мянга, аймаг, сумын ОНХС-гаар 16,722.0 мянга, БХНСАХЗ-аас 11,500.0 мянга, дахин үнэлгээ 6,961.0 мянга, Төрийн өмчийн хорооноос шилжүүлэн авсан 6,000.0 мянга нийт 156,261.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Аймгийн ИТХ-ын 2023 оны 06 дугаар тогтоолоор 306,374.1 мянган төгрөгийн конторын барилга, байгууллагын өмнөх талбайг шилжүүлсэн, аймгийн ИТХ-ын 2023 оны 158 дугаар захирамжаар 19,131.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталсан, 114 дүгээр захирамжаар 4,500.0 мянган төгрөгийн автомашиныг дуудлага худалдаагаар борлуулсан нийт 330,005.1 мянган төгрөгийн хөрөнгө хасагдсан байна.
- Өр төлбөр данс 9,143.0 мянган төгрөгөөр буурч өр төлбөргүй тайлагнасан байна.
- Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,829,397.0 мянган төгрөг болж 128,400.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.



### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,074,571.1 мянга, нийт зарлагыг 1,074,571.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 456,119.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 1,530,690.3 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсвийг үндэслэлтэй төлөвлөөгүйгээс шалтгаалсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 219,398.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 1 удаа тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 11 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,750,089.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр батлагдсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,750,089.1 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,666,246.1 мянган төгрөг буюу 95.2 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг 154.7 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл зардлыг 6,729.7 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 2,082.4 мянга, хангамж, бараа материалын зардлыг 1,779.5 мянга, эд хогшил худалдан авах зардлыг 3,321.1 мянга, томилолт, зочны зардлыг 3,830.3 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр зардлыг 4,273.4 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 60,921.9 мянга, бусад урсгал шилжүүлэг зардлыг 750.0 мянга нийт 83,843.0 мянган төгрөгийн зардлыг хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70106-80101	711,552.6	692,861.4	18,691.2	97.4
2	70106-80103	120,000.0	120,000.0	0.0	100.0
3	70106-80106	204,243.7	201,020.9	3,222.8	98.4
4	70106-80205	2,000.0	0.0	2,000.0	0.0
5	70106-80802	7,500.0	6,750.0	750.0	90.0
6	70106-81102	50,000.0	37,504.0	12,496.0	75.0
7	70106-81701	46,683.0	0.0	46,683.0	0.0
8	70106-82203	82,940.8	82,940.8	0.0	100.0
9	70106-82206	57,103.0	57,103.0	0.0	100.0
10	70106-82212	450,766.0	450,766.0	0.0	100.0
11	71602-80112	17,300.0	17,300.0	0.0	100.0
	<b>Нийт</b>	<b>1,750,089.1</b>	<b>1,666,246.1</b>	<b>83,843.0</b>	<b>95.2</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.



Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд өвсний орлого 27,265.0 мянга, аймгийн ИТХ хамтарсан багийн зардал 2,300.0 мянга, тендерийн орлого 1,575.0 мянга, Статистикийн хэлтсийн мал тооллогын урамшуулал 420.0 мянга, бусад орлого 45.0 мянга нийт 31,605.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Өвс худалдан авах зардалд 26,999.9 мянга, шагнал, урамшууллын зардалд 465.0 мянга, бичиг хэргийн зардалд 1,575.0 мянга, материалын зардалд 650.0 мянга, хөрөнгө худалдан авах зардалд 1,650.0 мянга, өмнөх оны өр төлбөр барагдуулалт 265.0 мянга нийт 31,605.0 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

### **3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.



## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүмбэр сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн газрын бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Анхтуяа, хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүмбэр сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 01/65 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлын дүн 1,271,021.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 12,710.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Тус байгууллагад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байна.



#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчил илрээгүй байна.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагад 2023 оны 3 дугаар улирлын байдлаар санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланд завсрын аудит гүйцэтгэж, нийт 8 горим сорилыг хэрэгжүүлж, асуудлын бүртгэлээр 56,728.8 мянган төгрөгийн 3 алдааг залруулах зөвлөмж өгсөн байна. Нийт 56,728.8 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

##### Залруулсан алдаа:

1. Үнэ төлбөргүй хүлээн авсан 53,530.0 мянган төгрөгийн 2 хүлэмжийг тусгай зориулалтын материал дансанд орлогод авсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4 дахь заалтуудыг зөрчсөн, УСНББОУС 1.27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйгээг үнэн зөв толилуулах ёстой", УСНББОУС-Бараа материал 12-44, ангилал батламж мэдэгдлийг хангаагүй
2. Няравын гаргасан тайлан нягтлан бодогчийн хянасан тайлангаас 3,066.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4 дэх заалтуудыг зөрчсөн, УСНББОУС 1.27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйгээг үнэн зөв толилуулах ёстой", УСНББОУС-Бараа материал 12-44, үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй
3. Нийт 2 ажилтны цалин, ээлжийн амралтыг давхардуулан 132.6 мянган төгрөг олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.4, 20.2.5, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дүгээр тушаалын хавсралтын 1 дүгээр зүйлийн 1.1, 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалтуудыг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	466.7	1	466.7	100
Албан шаардлага	2	28,678.5	2	28,678.5	100
Зөвлөмж	1	0.0	1	0.0	100
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>29,145.2</b>	<b>4</b>	<b>29,145.2</b>	<b>100</b>

Өмнөх аудитаар нийт 29,145.2 мянган төгрөгийн 4 зөрчил илрүүлж, 4,346.4 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 98,571.2 мянган төгрөгийн 5 зөрчилд албан шаардлага, 2 зөвлөмж өгсөн бөгөөд хэрэгжилтийг хянаж үзэхэд 100%-тай байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.



## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 8,015.5 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 8,015.5 мянган төгрөгийн алдааг залруулсан байна.

*Залруулсан алдаа:*

1. Хандив тусламжаар өгсөн 200.0 мянган төгрөгийг кассанд орлогоор бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4.5, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4 дэх заалтуудыг зөрчсөн, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй
2. Үндсэн хөрөнгийн шинж чанаргүй 1,815.5 мянган төгрөгийн 6 хөрөнгийг машин тоног төхөөрөмж дансанд бүртгэж орлогод авсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4 дэх заалтуудыг зөрчсөн, УСНББОУС 17.14-д Үндсэн хөрөнгө-Хүлээн зөвшөөрүүлэлт "Үндсэн хөрөнгийн өртгийг зөвхөн дараах тохиолдолд хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө: а) Тухайн хөрөнгөтэй холбоотой ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи нь тухайн байгууллагад орох нилээд их магадлалтай байх б) Тухайн хөрөнгийн өртөг буюу үйлчилгээний чадавхийг найдвартай хэмжих чадах", үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй
3. Төрийн өмчөөс шилжүүлсэн автомашиныг үнэлж бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4.2, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5 дахь заалтуудыг зөрчсөн, УСНББОУС 17.14-д Үндсэн хөрөнгө-Хүлээн зөвшөөрүүлэлт "Үндсэн хөрөнгийн өртгийг зөвхөн дараах тохиолдолд хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө: а) Тухайн хөрөнгөтэй холбоотой ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи нь тухайн байгууллагад орох нилээд их магадлалтай байх б) Тухайн хөрөнгийн өртөг буюу үйлчилгээний чадавхийг найдвартай хэмжих чадах", иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй

*Залруулаагүй алдаа:*

Байхгүй

Аудитаар нийт 3,437.9 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 2,937.9 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 500.0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

1. Хоёр албан хаагчид улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан хууль тогтоомжид заагаагүй хэлбэрээр цалингийн зардлаас урамшуулал олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.1.3, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.2, Засгийн газрын 2023 оны 442-р тогтоолын хавсралтаар өөрчлөлт орсон 2.2 дахь заалтуудыг зөрчсөн, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.



## 5.2 Албан шаардлага

1. 2022 онд өр төлбөрийн дансанд тусгаагүй тэтгэмжийг 2023 онд нөхөн олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4.3, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4 дэх заалтуудыг зөрчсөн, УСНББОУС 1.27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйгээг үнэн зөв толилуулах ёстой", оршин байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

## 5.3 Зөвлөмж

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Аймгийн Засаг даргын 2021 оны А/420 дугаар захирамжаар "Орон сууц хаус" зориулалтаар олгосон 6672м<sup>2</sup>, 2021 оны А/143 дугаар захирамжаар олгосон "Үйлчилгээ халуун ус" зориулалтаар олгосон 1340м<sup>2</sup>, 2013 оны А/185 дугаар захирамжаар "Албан байр" зориулалтаар олгосон 1049м<sup>2</sup> нийт 3 газрын эзэмших эрхийг үнэлж бүртгээгүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.1, 14.4.2, Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх заалтуудыг зөрчсөн, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Засаг даргын захирамжаар олгосон нийт 3 газар эзэмших эрхийг үнэлж данс бүртгэлд тусгах

Санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлагыг тогтоосон хугацаанд хэрэгжүүлж, зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үнэ төлбөргүй хүлээн авсан 2 хүлэмжийг тусгай зориулалтын материал дансанд орлогод авсан	1	53,530.0			1	53,530.0	1	53,530.0				
Няравын гаргасан тайлан нягтлан бодогчийн хянасан тайлангаас зөрүүтэй тайлагнасан	1	3,066.2			1	3,066.2	1	3,066.2				
Нийт 2 ажилтны цалин, ээлжийн амралтыг давхардуулан олгосон	1	132.6			1	132.6	1	132.6				
Хандив тусламжаар өгсөн 200.0 мянган төгрөгийг кассанд орлогоор бүртгээгүй	1	200.0	1	200.0			1	200.0				
Үндсэн хөрөнгийн шинж чанаргүй 6 хөрөнгийг машин тоног төхөөрөмж дансанд бүртгэж орлогод авсан	1	1,815.5			1	1,815.5	1	1,815.5				
Төрийн өмчөөс шилжүүлсэн автомашиныг үнэлж бүртгээгүй	1	6,000.0	1	6,000.0			1	6,000.0				
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>64,744.3</b>	<b>2</b>	<b>6,200.0</b>	<b>4</b>	<b>58,544.3</b>	<b>6</b>	<b>64,744.3</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал



	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
2022 онд өр төлбөрийн дансанд тусгаагүй тэтгэмжийг 2023 онд нөхөн олгосон	1	500.0			1	500.0						
2 албан хаагчид улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан хууль тогтоомжид заагаагүй хэлбэрээр цалингийн зардлаас урамшуулал олгосон	1	2,937.9	1	2,937.9								
Аймгийн Засаг даргын 2021 оны А/420 дугаар захирамжаар "Орон сууц хаус" зориулалтаар олгосон 6672м2, 2021 оны А/143 дугаар захирамжаар олгосон "Үйлчилгээ халуун ус" зориулалтаар олгосон 1340м2, 2013 оны А/185 дугаар захирамжаар "Албан байр" зориулалтаар олгосон 1049м2 нийт 3 газрын эзэмших эрхийг үнэлж бүртгээгүй	1	0.0					1	0.0				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>3,437.9</b>	<b>1</b>	<b>2,937.9</b>	<b>1</b>	<b>500.0</b>	<b>1</b>	<b>0.0</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/								
	Нийт зөрчил		Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
<b>Дүн</b>									
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
<b>Дүн</b>									
<b>Нийт дүн</b>									



АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ

Байгууллагын нэр: Сүмбэр сумын Засаг даргын тамгын газар  
Байгууллагын РД: 9018611

Аудитын код:  
Аудитын нэр:  
Тайлант хугацаа:

ГСА-2024/32/НА-СТА-ТШЗ  
Санхүүгийн тайлангийн аудит  
2023.01.01-2023.12.31

№	АГАДУТ	АГАДУТ-ийн дэд анги	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгагдагч байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн хариу, тайлбар	Гаргасан шийдэл	Шалгагдагч байгууллагын холбогдох хүний	
									Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5	6	7	8	9	10
<b>1. Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдааны бүртгэл</b>										
1	Тодруулга-Бараа материал	Бараа материал	Нийт 2 хүлэмжийг тусгай зориулалтын материал дансанд орлогод авсан	53,530,000.0	Завсрын аудитаар залруулсан	зөвшөөрсөн		Завсрын аудитаар залруулсан	Дарга, нягтлан бодогч	П.Наранмандах, Б.Болор-Эрдэнэ
2	Тодруулга-Бараа материал	Бараа материал	Няравын гаргасан тайлан нягтлан бодогчийн хянасан тайлангаас зөрүүтэй тайлагнасан	3,066,183.0	Завсрын аудитаар залруулсан	зөвшөөрсөн		Завсрын аудитаар залруулсан	Дарга, нягтлан бодогч	П.Наранмандах, Б.Болор-Эрдэнэ
3	Урсгал зардал	Цалин	Нийт 2 ажилтны цалин, ээлжийн амралтыг давхардуулан олгосон	132,590.0	Завсрын аудитаар залруулсан	зөвшөөрсөн		Завсрын аудитаар залруулсан	Дарга, нягтлан бодогч	П.Наранмандах, Б.Болор-Эрдэнэ
4	Мөнгөн хөрөнгө	Мөнгөн хөрөнгө	Хандив тусламжаар өгсөн 200.0 мянган төгрөгийг кассанд орлогоор бүртгээгүй	200,000.0	Залруулга	зөвшөөрсөн		Залруулга	Дарга, нягтлан бодогч	П.Наранмандах, Б.Болор-Эрдэнэ
5	Тодруулга-Үндсэн хөрөнгө	Үндсэн хөрөнгө	Үндсэн хөрөнгийн шинж чанаргүй 6 хөрөнгийг машин тоног төхөөрөмж дансанд бүртгэж орлогод авсан	1,815,500.0	Залруулга	зөвшөөрсөн		Залруулга	Дарга, нягтлан бодогч	П.Наранмандах, Б.Болор-Эрдэнэ
6	Тодруулга-Үндсэн хөрөнгө	Үндсэн хөрөнгө	Төрийн өмчөөс шилжүүлсэн автомашиныг үнэлж бүртгээгүй	6,000,000.0	Залруулга	зөвшөөрсөн		Залруулга	Дарга, нягтлан бодогч	П.Наранмандах, Б.Болор-Эрдэнэ
<b>Алдааны дүн</b>				<b>64,744,273.0</b>						
<b>2. Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн бүртгэл</b>										
1	Нийт зардал	Зардал	2022 онд өр төлбөр дансанд тусгаагүй тэтгэмжийг 2023 онд нөхөн олгосон	500,000.0	Албан шаардлага өгөх	зөвшөөрсөн		Албан шаардлага өгөх	Дарга, нягтлан бодогч	П.Наранмандах, Б.Болор-Эрдэнэ
2	Урсгал зардал	Цалин	2 албан хаагчид улирлын үр дүнгийн урамшуулалттай давхардуулан хууль тогтоомжид заагаагүй хэлбэрээр цалингийн зардлаас урамшуулал олгосон	2,937,906.0	Төлбөрийн акт тогтоох	зөвшөөрсөн		Төлбөрийн акт тогтоох	Дарга, нягтлан бодогч	П.Наранмандах, Б.Болор-Эрдэнэ
3	Тодруулга-Үндсэн хөрөнгө	Үндсэн хөрөнгө	Аймгийн Засаг даргын 2021 оны А/420 дугаар захирамжаар "Орон сууц хаус" зориулалтаар олгосон 6672м2, 2021 оны А/143 дугаар захирамжаар олгосон "Үйлчилгээ халуун ус" зориулалтаар олгосон 1340м2, 2013 оны А/185 дугаар захирамжаар "Албан байр" зориулалтаар олгосон 1049м2 нийт 3 газрын эзэмших эрхийг үнэлж бүртгээгүй	-	Зөвлөмж өгөх	зөвшөөрсөн		Зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	П.Наранмандах, Б.Болор-Эрдэнэ
<b>Зөрчлийн дүн</b>				<b>3,437,906.0</b>						
<b>3. Нийцлийн аудитын асуудлын бүртгэл</b>										
<b>3. Нийцлийн аудитын асуудлын дүн</b>				<b>68,182,179.00</b>						

Бэлтгэсэн: Ахлах аудитор / Б.Анхтүвш / Огноо: 2024.02.22  
Хянасан: Аудитын менежер / Г.Наранбаяр / Огноо: 2024.02.22  
Хянасан: Дарга, Тэргүүлэх аудитор / Б.Сарантүвш / Огноо: 2024.02.22



Танилцаж зөвшөөрсөн:  
Дарга: / П.Наранмандах /  
Нягтлан бодогч: / Б.Болор-Эрдэнэ /  
Огноо: 2024.02.22







ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2024 оны 08 сарын 23 өдөр

Дугаар

48/А0861082

Чойр

ГСА-2024/22/НА-СА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын "Засаг даргын тамгын газар"-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- ✓ Тайлант онд 2 албан хаагчид улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан цалингийн зардлаас хууль тогтоомжид заагаагүй 2,937.9 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4-т "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна", Засгийн газрын 2023 оны 442 дугаар тогтоолын хавсралтаар өөрчлөлт орсон 2.2 гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйл, Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно," Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3-т "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.3-т "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон урамшууллын нийт 2,937,906.00 (Хоёр сая есөн зуун гучин долоон мянга есөн зуун зургаан) төгрөгийг удирдлага, санхүүгийн ажилтан нар хариуцан барагдуулж,

008050151



Говьсүмбэр аймгийн Төрийн сан дахь орон нутгийн орлогын “Төсөвт байгууллагын өөрийн орлого” 100220000954 тоот дансанд төвлөрүүлэх

- Актын биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар<sup>1</sup>т ирүүлэхийг Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Засаг даргын тамгын газрын дарга П.Наранмандах, нягтлан бодогч Б.Болор-Эрдэнэ нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР



Б.САРАНТУЯА

Б.АНХТУЯА

<sup>1</sup> Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, Найрамдал хотхон, Нутгийн удирдлагын ордон, Утас:70543179



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 26/А0861082

Чойр

ГСА-2024/32/НА-СА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Говьсүмбэр аймгийн "Сүмбэр сумын Засаг даргын тамгын газар"-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- ✓ 2022 онд өр төлбөрийн дансанд тусгаагүй 500.0 мянган төгрөгийн тэтгэмжийг 2023 онд нөхөн олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.3-т "бүх өр төлбөр", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйл, Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1-т "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.", 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй", 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Өр төлбөрт тусгаагүй тэтгэмжийг тайлант хугацаанд нөхөн олгосон зөрчлийг давтан гаргахгүй байх, биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар<sup>1</sup>т ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Засаг даргын тамгын дарга П.Наранмандах, нягтлан бодогч Б.Болор-Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Б.САРАНТУЯА

Б.АНХТУЯА

421714454  
УСА0055 9019049

<sup>1</sup> Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, Найрамдал хотхон, АЗДТГ-ын байр, Утас:70543179

008040066



